

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, САНГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 10 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 191
№112

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хилийн Гашуунсухайт боомтын уул уурхайн экспортын тээвэрлэлт, орон нутгийн төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Гашуунсухайт боомтоор уул уурхайн экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уул уурхайн экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Шуурхай штабын даргад үүрэг болгосугай.


3. Шуурхай штабын үйл ажиллагааны зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржид даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Хилийн боомтын үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч И. Батхүү нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
С.АМАРСАЙХАН

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын
хамтарсан 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын Хавсралт 1



ГАСУУНСУХАЙТ ДАХЬ ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Штабын дарга:

-Онцгой байдлын ерөнхий газрын
удирдах албан тушаалтан,

Орлогч:

-Мэргэжлийн хяналтын ерөнхий
газрын хэлтсийн дарга,

Гишүүд:

-Цагдаагийн ерөнхий газрын хэв
журам сахиулах асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн,

-Хил хамгаалах ерөнхий газрын ахлах
мэргэжилтэн,

-Зэвсэгт хүчний Жанжин штабын
ахлах мэргэжилтэн,

-Тагнуулын ерөнхий газрын ахлах
мэргэжилтэн,

-Автотээрийн үндэсний төвийн ахлах
мэргэжилтэн,

-Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн тасгийн дарга,

Зооноз өвчин судлалын үндэсний
төвийн мэргэжилтэн

-Өмнөговь аймгийн Ханбогд сумын
Засаг даргын орлогч,

-Өмнөговь аймгийн Ханбогд сумын
Хайрхан багийн Засаг дарга,

-Өмнөговь аймгийн Цагдаагийн
газрын хэв журам сахиулах асуудал
хариуцсан ахлах байцаагч,

-Өмнөговь аймгийн Онцгой байдлын
газрын гамшиг, гал түймрийн улсын
хяналтын байцаагч,

-Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн төвийн нийтийн эрүүл мэндийн асуудал хариусан мэргэжилтэн,

Тээвэр эрхлэж байгаа аж ахуйн нэгж, холбоодын төлөөлөл /зөвшилцсөнөөр, 2-оос ихгүй/

Нарийн бичиг:

-Онцгой байдлын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн,

-Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч,

---000---

Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын
хамтарсан 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн..... дугаарын тушаалын хавсралт 2

ГASHУУНСУХАЙТ БООМТООР УУЛ УУРХАЙН ЭКСПОРТЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү түр журмын зорилго нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал (цаашид “КОВИД-19” гэх)-ын үед Гашуунсухайт хилийн боомтоор уул уурхайн экспортын тээвэрлэлтийг удирдлага зохицуулалтаар хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгж, иргэний халдвар хамгааллын дэглэм сахиулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, түүнд хяналт тавьж буй төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлоход оршино.

1.2.Энэхүү түр журам /цаашид “журам” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3.Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Гашуунсухайт боомт дахь Хилийн боомтын зөвлөл, Шуурхай штаб, орон нутгийн Онцгой комиссын үйл ажиллагааг удирдаж, ажил, үр дүнгийн талаар Хилийн боомтын үндэсний зөвлөлд танилцуулж байна.

1.4.Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1.“Битүүмжлэгдсэн тээврийн баг” гэж суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулах зорилгоор багийн зохион байгуулалтанд орсон тээврийн үйл ажиллагаа эрхлэх жолоочдын багийг;

1.4.2.“суурьшлын бүс” гэж Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаанхад орчмын нутаг дэвсгэрийг;

1.4.3.“ПГУ-ын шинжилгээ” гэж Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх лабораторийн шинжилгээг.

Хоёр.Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа

2.1.Гашуунсухайт дахь Шуурхай штабын эрх, үүрэг.

2.1.1.Гашуунсухайт боомтын Шуурхай штаб (цаашид “Шуурхай штаб” гэх)-ын үйл ажиллагаа нь суурьшлын бүсэд байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, урьдчилан сэргийлэх, тусгаарлалтын бүсийн хамгаалалт, хэв журам сахиулах, лабораторийн шинжилгээ оношилгооны найдвартай шуурхай байдлыг хангах, орон нутгийн бүх шатны онцгой комисс болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэнэ.

2.1.2. Шуурхай штабын бүрэлдэхүүн нь дарга, орлогч дарга болон гишүүдээс бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна.

2.1.3. Шуурхай штабын дарга нь штабын хэвийн үйл ажиллагааг хангах, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагаа, ажил үүргийн хуваарийг тогтоох, үүрэгжүүлэх, үүргийн биелэлтийг хангуулах, хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүнд холбогдох байгууллагын саналыг үндэслэн холбогдох албан тушаалтныг өөрчлөх асуудлыг шийдвэрлэнэ.

2.1.4. Шуурхай штабын орлогч дарга нь штабын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь, гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2.1.5. Шуурхай штабын гишүүд нь тогтоосон ажил үүргийн хуваарь, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шуурхай хангаж, дарга, орлогч даргын шууд удирдлагад үүрэг гүйцэтгэнэ.

2.1.6. Шуурхай штабын хөдөлмөрийн дотоод журмыг Шуурхай штабын дарга батална.

2.1.7. Шуурхай штаб нь дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлж ажиллана:

2.1.7.а. Шаардлагатай тохиолдолд аймаг, сумын Онцгой комиссын удирдлагыг штабын үйл ажиллагаанд татан оролцуулах, бүх талын дэмжлэг авах;

2.1.7.б. Суурьшлын бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг халдвараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжөөр хангах, халдвар хамгааллын дэглэм сахиулах, хяналт тавих;

2.1.7.в. Шаардлагатай тохиолдолд тусгаарлах байр, кемп, үйлчилгээний газрууд, тээврийн машин техникт хяналт шалгалтыг зохион байгуулах, гарсан зөрчлийг арилгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.1.7.г. Цагаанхад суурьшлын бүс дэх тусгаарлалтын бүсэд эргүүл хамгаалалтыг тогтоох, хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах;

2.1.7.д. ПГУ-ын шинжилгээг тасралтгүй зохион байгуулах, шинжилгээний баталгаатай байдлыг хангуулахад шаардлагатай холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.7.е. Холбогдох мэдээ мэдээлэл, бүртгэл, тооцоог нэгтгэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, эрх бүхий албан тушаалтан, дээд шатны байгууллагыг мэдээллээр шуурхай хангах;

2.1.7.ё. Шуурхай штабын хариуцсан үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан санал, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх;

2.1.7.ж.Суурьшлын бүсэд нэвтрэх, гарах битүүмжлэгдсэн тээврийн баг, аж ахуйн нэгж, иргэн, ажилтан, албан хаагчдад холбогдох баримт бичиг, шинжилгээний хариуг үндэслэн зөвшөөрөл олгож, хөдөлгөөний тоон мэдээг тухай бүр нэгтгэн, мэдээллийн санд бүртгэх;

2.1.7.з.Үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.1.7.и.Суурьшлын бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагч, иргэдийг вакцинд хамруулах ажлыг зохион байгуулах.

2.1.7.й.Суурьшлын бүсэд битүүмжлэгдсэн тээврийн багт ПГУ-ын шинжилгээний “эерэг” хариу гарсан тохиолдол, түүний ойрын хавьтал /нэг өрөө, гэрт хамт байсан хүн/-ыг суурьшлын бүсээс гаргах ажлыг шуурхай зохион байгуулан бүртгэлжүүлж, тусгаарлан ажиглах байранд шилжүүлэх асуудлыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хариуцуулж, тухайн шатны Онцгой комисс хяналт тавина.

2.1.8.Аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлтийн дагуу битүүмжлэгдсэн тээврийн баг үүсгэх асуудлыг судлан, тусгаарлах байраар ашиглах кемп, байр сууцанд мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулж холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж дүгнэлт гаргаж Хилийн боомтын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.2.Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, Хилийн боомтын зөвлөлийн үйл ажиллагаа.

2.2.1.Автотээврийн үндэсний төвийн Цогтцэций салбар (цаашид “Автотээврийн байгууллага” гэх)-аас ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу битүүмжлэгдсэн тээврийн багуудын хил нэвтрэх дараалал тогтоосон жагсаалтыг Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, Хилийн боомтын зөвлөлийн гишүүд хамтран албажуулна.

2.2.2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (цаашид “Хятадын тал” гэх) талын татан авалт, хил хаасантай холбоотойгоор үүсэх нөхцөл байдал, жагсаалтад орсон битүүмжлэгдсэн тээврийн багаас эерэг тохиолдол гарч тээвэр эрхлэх боломжгүй болсон тохиолдолд журмын 2.2.1-д заасан жагсаалтад тухай бүр өөрчлөлт оруулна.

2.2.3.Хилийн боомтод халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлнэ.

2.2.4.Битүүмжлэгдсэн тээврийн баг үүсгэх асуудлыг энэхүү түр журмын 2.1.8-д заасан дүгнэлт болон Автотээврийн үндэсний төвийн саналыг үндэслэн хурлаар хэлэлцэж хамтын шийдвэр гаргана.

2.3.Автотээврийн байгууллагын үйл ажиллагаа.

2.3.1.Автотээврийн байгууллага нь хилийн боомтын ачаа тээврийн эргэлтийг үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зохицуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллана.

2.3.2.Журмын 2.2.1-д заасан хуваарийн дагуу шинжилгээнд хамрагдах жолоочийн мэдээллийг суурьшлын бүс дэх ПГУ-ын шинжилгээ авах байгууллагад, ачилтад орох тээврийн хэрэгсэл, жолоочийн мэдээллийг Гашуунсухайт боомт дахь гаалийн газарт тус тус хүргүүлнэ.

2.3.3.Хятадын талын шинжилгээнд хамрагдах битүүмжлэгдсэн багуудын автобусыг дугаарлаж, дарааллын дагуу хилийн боомт руу хөдөлгөх арга хэмжээг авна.

2.3.4.Битүүмжлэгдсэн тээврийн багийн бүртгэлийг хөтөлж, бүртгэлд дараах тохиолдолд өөрчлөлт оруулж шинэчлэнэ:

2.3.4.а.Улс хоорондын тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийн хүчинтэй хугацаа дуусахад тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагаас дараагийн улиралд өөр тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд тээврийн хэрэгслийн мэдээллийг өөрчилж болох бөгөөд солигдож орох тээврийн хэрэгсэл ачилт хийгдээгүй байх шаардлагыг хангасан байх;

2.3.4.б.Жолоочийн гадаад паспорт өөрчлөгдсөн, шинээр авсан тохиолдолд шинээр олгогдсон гадаад паспортын дугаарын мэдээллийг шинэчлэх;

2.3.4.в.Битүүмжлэгдсэн тээврийн багийн жолоочийн шинжилгээний хариу эерэг гарсан, ар гэрийн гачигдал, өөрийн хүсэлтээр багаас гарсан тохиолдолд дараагийн жолооч оруулах, битүүмжлэгдсэн тээврийн багийг хуваах, нэгтгэх.

2.3.5.Аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг үндэслэн журмын 2.3.4.в-д заасан битүүмжлэгдсэн тээврийн багийг хуваах, нэгтгэх, асуудлыг Шуурхай штаб танилцуулж Хилийн боомтын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

2.4.Суурьшлын бүс дэх эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа.

2.4.1.Эмч, эмнэлгийн мэргэжилтний нөөц, зохион байгуулалтаар хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай хүргэнэ.

2.4.2.Зохих журмын дагуу үүссэн, битүүмжлэгдсэн тээврийн багийн хүмүүсээс авах ПГУ-ын шинжилгээг хуваарийн дагуу зохион байгуулж, шинжилгээний хариуг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлнэ.

2.4.3. Битүүмжлэгдсэн тээврийн багийн эмч нарыг удирдлага арга зүйгээр хангаж, жолооч, нүүрс ачиж буулгах талбай, суурьшлын бүсийн иргэдийг “КОВИД-19” халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4.4. Суурьшлын бүсэд нэвтрэх битүүмжлэгдсэн тээврийн багаас ПГУ-ын шинжилгээ авна.

2.4.5. “КОВИД-19” халдварын тандалт судалгаа, өвчлөлийн тоон мэдээлэл болон битүүмжлэгдсэн тээврийн багийн шинжилгээний дүнгийн талаарх бүртгэлийг өдөр бүр нэгтгэн, дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр шуурхай хангана.

2.5. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа.

2.5.1. “КОВИД-19”-тэй холбоотой батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангана.

2.5.2. Тусгаарлан ажиглах байр болон түр тусгаарлах байранд тавигдах шаардлагыг хангуулах, биелэлтэд хяналт тавина.

2.5.3. Аж ахуйн нэгж байгууллагын “КОВИД-19” халдвараас урьдчилан сэргийлэх байнгын халдваргүйжүүлэлт хийж байгаа болон сэжигтэй тохиолдол гарсан үед голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэж, байгаа байдалд хяналт тавина.

2.5.4. Аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн болон халдвартай хог хаягдлаа ангилан цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд нь хяналт тавина.

2.5.5. Битүүмжлэгдсэн тээврийн баг нь эрүүл ахуй халдвар хамгаалал хангаагүй, сэжигтэй болон ойрын хавьтлыг түр тусгаарлах байргүй аж ахуйн нэгжид ажлын хэсгийн шалгалтын үр дүнгээр хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулна.

2.5.6. Хилээр нэвтрэх цэгт “КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.6. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа

2.6.1. Суурьшлын бүсэд нэвтрэх байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд, иргэд, жолооч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ халдвар хамгааллын дэглэмийг баримталж, Шуурхай штабын шийдвэрийн дагуу нэвтрүүлнэ.

2.6.2. Битүүмжлэгдсэн тээврийн багийн амрах байранд байрласан жолооч нарын нийтийн хэв журам сахиулан, битүүмжлэгдсэн тээврийн багийн орчинд архи согтууруулах ундаагаар үйлчилж буй иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоож, хуулийн дагуу хариуцлага тооцно.

2.6.3. Шуурхай штабаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу “эерэг” хариу гарсан битүүмжлэгдсэн тээврийн багийг суурьшлын бүсээс албадан гаргана.

2.6.4. Суурьшлын бүсээс эерэг тохиолдол бүртгэгдэж гарсан аж ахуйн нэгжийн битүүмжлэгдсэн багийг буцааж оруулахдаа Шуурхай штабын олгосон зөвшөөрлийг үндэслэн холбогдох баримт бичгийг шалгаж нэвтрүүлнэ.

2.6.5. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын онцгой комисс болон аймгийн онцгой комиссоос гарсан шийдвэр, аймаг, сумын Засаг даргын захирамжаар цагдаагийн байгууллагад даалгасан ажлыг зохион байгуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

2.7. Сумын онцгой комиссын үйл ажиллагаа.

2.7.1. Тусгаарлагдан битүүмжлэгдсэн тээврийн багийн мэдээллийг бүртгэлжүүлж, тусгаарлалтын хугацаанд хяналт тавина.

2.7.2. Тусгаарлалтын хугацаа дуусч суурьшлын бүсэд нэвтрэх битүүмжлэгдсэн тээврийн багийг тусгаарлах хугацаанд журмын дагуу байрласан эсэх талаар тухайн сумын Онцгой комисс албан бичгээр баталгаажуулан Шуурхай штабт ирүүлнэ.

Гурав. Тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, жолооч нарт тавигдах шаардлага, хүлээх үүрэг

3.1. Аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг.

3.1.1. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь экспорт, импортын тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нарыг 40 хүртэлх хүнтэй битүүмжлэгдсэн багийн зохион байгуулалтад оруулж, баг тус бүр багийн бус бусад хүнтэй аливаа харилцаа, хавьтал үүсгэхгүйгээр ажиллах, амрах, хооллох эрүүл ахуйн хэрэгцээ шаардлагаар хангагдсан тусгаарлах кемптэй байна.

3.1.2. Тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн кемпийг мэргэжлийн байгууллагуудад шалгуулж, шаардлага хангасан талаар дүгнэлт гаргуулсан байна.

3.1.3. Жолооч нарыг битүүмжлэгдсэн багийн зохион байгуулалтад оруулж мэдээллийг автотээврийн байгууллагад хүргүүлнэ.

3.1.4. Аж ахуйн нэгжүүд битүүмжлэгдсэн баг тус бүрийг ПГУ-ын шинжилгээнд хамруулах, тээврийн хэрэгсэл, амрах байр хооронд автобусаар зөөвөрлөх ажлыг зохион байгуулж, үүнтэй холбоотой бүх зардлыг хариуцна.

3.1.5. Улс хоорондын тээврийн жолоочийг хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, маск, бээлий, малгай, нүүрний хаалт зэрэг), ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодис, анхны тусламжийн хайрцаг, боолтын материал, биеийн халуун хэмжигч, эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас зэргээр хангана.

3.1.6.Өөрийн харьяаллын жолоочийг тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

3.1.7.Тээвэрлэлт эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь жолооч нөхөж оруулах зөвшөөрөл гарсны дараа Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдад 14 хоног тусгаарлагдан ажиглалтад хянагдаж, шинжилгээний сөрөг хариу гарсны дараа жолоочийг Цагаанхад суурьшлын бүс дэх тусгаарлагдах кемпэд байрлуулна.

3.1.8.Тээвэрлэлтэд гарахаас өмнө автобус, тээврийн хэрэгслийн дотор болон гадаргын ариутгал халдваргүйжүүлэлтийг хийнэ.

3.2.Жолоочийн хүлээх үүрэг.

3.2.1.Жолооч аж ахуйн нэгжтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, харьяалсан аж ахуйн нэгжид тогтвортой ажиллан, оногдсон тээврийн хэрэгслийг солихгүйгээр тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

3.2.2.Жолооч аж ахуйн нэгж байгууллагын хуваарилсан багийн амрах байранд байрлаж, тухайн багийн бүрэлдэхүүний хамтаар тээвэрлэлтэд оролцоно.

3.2.3.Амны хаалтыг хүрэлцэхүйц хэмжээтэй нөөцөлж, 2 цаг тутам сольж, хамгаалалтын цагаан хувцсыг аюултай хог хаягдлын уутанд цуглуулан зориулалтын хогийн цэгт хаяна.

3.2.4.Жолооч нь ил задгай нус, шүлс, хог хаяхгүй, бие засахгүй байж шаардлагатай тохиолдол бүрд гарыг халдваргүйжүүлж, хог хаягдлыг хогийн уутанд цуглуулан, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяна.

3.2.5.Халдваргүйжүүлэх боломжгүй эд зүйлс болох ор хөнжлийн хэрэглэл болон бусад зөөлөн эдлэл, суудлын даавуун бүрээс, даавуун хөшиг, чимэглэл зэргийг бүхээгт байлгахыг хориглоно.

3.2.6.Тээврийн хэрэгслийг хилийн боомтын нэвтрэх цэг болон бусад тогтоосон цэгт зогсоож, халдваргүйжүүлэлтийг хийлгэж, эрх бүхий байгууллагын ажилтны зөвлөмж зааврыг мөрдөнө.

3.2.7.Жолооч “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг үнэн зөв бөглөнө.

3.2.8.Битүүмжлэгдсэн багийн бүрэлдэхүүнд байгаа жолооч шинжилгээнд хамрагдах, хилийн боомтоор нэвтрэх үед автобус хооронд холилдохгүй, амрах байраар сэлгүүцэхгүй байж, төрийн байгууллагын ажилтнуудын үүрэг, даалгаврыг биелүүлэн, хариуцлага ёс зүйтэй байна.

3.2.9.Жолооч тусгаарлах, амрах байранд байрлах үедээ нийтийн хэв журмыг сахиж, хутга мэс биедээ авч явах, архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах эм, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглоно.

Дөрөв.ПГУ-ын шинжилгээ авах, тусгаарлан ажиглалт зохион байгуулах

4.1.Гашуунсухайт боомтоор нэвтрэхээс 24 цагийн өмнө суурьшлын бүсэд битүүмжлэгдсэн тээврийн баг ПГУ-ын шинжилгээ өгнө.

4.2.Суурьшлын бүсэд битүүмжлэгдсэн тээврийн багт ПГУ-ын шинжилгээний “эерэг” хариу гарсан тохиолдол, түүний ойрын хавьтал /нэг өрөө, гэрт хамт байсан хүн/-ыг суурьшлын бүсээс гаргах ажлыг шуурхай зохион байгуулан бүртгэлжүүлж, тусгаарлан ажиглах байранд шилжүүлэх асуудлыг Шуурхайн штаб тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хариуцуулж, тухайн шатны Онцгой комисс хяналт тавина.

4.3.Эерэг тохиолдол болон түүний ойрын хавьтлаас бусад сөрөг хариутай жолооч нарыг тухайн аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу өөрийн кемпэд 21 хоног тусгаарлах шийдвэрийг Шуурхай штаб гаргаж болно.

4.4.Журмын 4.3-т зааснаар тусгаарлагдан битүүмжлэгдсэн багийн жолооч нараас 6, 13 дахь хоногт хяналтын ПГУ-ын шинжилгээ авч, дараалсан 2 шинжилгээний хариу “сөрөг” гарч бүртгэгдсэн тохиолдолд битүүмжлэгдсэн тээврийн багийг тээврийн үйл ажиллагаанд шилжүүлнэ.

4.5.Тухайн битүүмжлэгдсэн тээврийн багийн 6 дахь хоногийн хяналтын шинжилгээнд “эерэг” тохиолдол бүртгэгдвэл Шуурхай штаб битүүмжлэгдсэн тээврийн багийг бүхэлд нь суурьшлын бүсээс гаргана.

4.6.Журмын 4.5-д зааснаар суурьшлын бүсээс гарсан битүүмжлэгдсэн тээврийн баг 14 хоногийн тусгаарлалтад байсан тухай холбогдох шатны Онцгой комиссын нотлох албан бичиг, 14 хоногийн хугацаанд дараалсан 2 (6 болон 13 дахь хоног) удаагийн ПГУ-ын шинжилгээний баталгаажсан “сөрөг” хариуг үндэслэн буцаж нэвтрэх эрх үүснэ.

4.7.Хятадын талд битүүмжлэгдсэн тээврийн багийн жолоочоос ПГУ-ын шинжилгээний “эерэг” хариу бүртгэгдвэл батлагдсан тохиолдол, түүний ойрын хавьтлыг суурьшлын бүсээс гаргах ажлыг шуурхай зохион байгуулан бүртгэлжүүлж, тусгаарлан ажиглах байранд шилжүүлэх асуудлыг Шуурхай штаб тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хариуцуулж, тухайн шатны Онцгой комисс хяналт тавина.

4.8.Журмын 4.7-д зааснаас бусад битүүмжлэгдсэн тээврийн багийн жолоочдод журмын 4.3-4.6-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

4.9.Шуурхай штаб суурьшлын бүс дэх бусад оршин суугчидтай холбогдуулан дараах арга хэмжээ авна:

4.9.1.Суурьшлын бүсийн оршин суугч, нүүрс ачилт буулгалтын талбайн ажилтнуудаас “КОВИД-19” халдвар илэрвэл батлагдсан тохиолдлыг суурьшлын бүсээс гаргаж, харьяалах орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, ойрын хавьтлыг тусгаарлан ажиглана;

4.9.2.Суурьшлын бүсэд тухайн орон нутгийн Онцгой комиссын 14 хоног тусгаарлагдсаныг нотлох бичиг, оршин суугчийн тодорхойлолт болон түүнтэй

адилтгах баримт бичиг, 48 цагийн ПГУ-ын шинжилгээний хариуг үндэслэн суурьшлын бүсэд нэвтрүүлнэ;

4.9.3.Суурьшлын кемп, нүүрс ачиж буулгах талбайн ажилтан, худалдаа үйлчилгээ, барилга, бүтээн байгуулалтад оролцож буй байгууллагын нийт ажилтан, албан хаагч, жолооч нарын 20 хувийг 21 хоногт 1 удаа “КОВИД-19” илрүүлэх шинжилгээнд хамруулна;

4.9.4.Ноцтой болон удаа дараа зөрчил дутагдал гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулахгүй байх шийдвэр гаргах, холбогдох зөвшөөрлийг цуцлах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Тав.Бусад

5.1.Журамд заасан эрх бүхий этгээд нь тээвэр эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага, түүний жолооч дараах зөрчлүүдийг гаргасан тохиолдолд “С” зөвшөөрлийг цуцалж, суурьшлын бүсээс гаргана.

5.1.2.Халдвар тархах нөхцөл бүрдүүлсэн;

5.1.3.Боомтын зөвлөл, шуурхай штабын шийдвэрийг биелүүлээгүй;

5.1.4.Хуваарьт ороогүй тээврийн хэрэгслээр нүүрс ачиж буулгах талбайгаас ачилт хийсэн;

5.1.5.Автотээврийн байгууллагатай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-нд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээ хүчингүй болсон тохиолдолд.

5.2.Ажил үүргийн хувьд олж мэдсэн хувь хүний болон албаны нууцыг албан тушаалтан задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

5.3.Журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---